

# ЗАХ ЗЭЭЛИЙН ӨРСӨЛДӨӨНИЙ ОРЧИН БА БИЗНЕСИЙН ОРЧИН

*Д. Алтанцэцэг*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
altantsetseg\_d@must.edu.mn*

*Т. Нарантуяа*

*Доктор (Ph. D.), дэд профессор  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль  
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль  
narantuyat@must.edu.mn*

*Хураангуй: Энэхүү нийтлэлд өрсөлдөөний орчны тодорхойлолтын хандлагуудыг тайлбарлаж, "өрсөлдөөний орчин" ба "бизнесийн орчин" ойлголтуудын нийтлэг ба ялгаатай шинж чанаруудыг нэгтгэж, өрсөлдөөний орчны гол шинж чанаруудыг тодорхойллоо.*

*Тулхуур үгс: Нутаг дэвсгэр, бүтээгдхүүн, ашиг*

## І. УДИРТГАЛ

Өрсөлдөөний орчны үзэл баримтлал В.Ойкены "Өрсөлдөөний дүрэм"-ийн онолын нөлөөгөөр 20-р зууны хоёрдугаар хагаст Герман улсад шинжлэх ухааны мэтгэлцээний явцад бий болжээ. Өрсөлдөөний орчны тухай үзэл баримтлал нь эдийн засгийн үйл явцын даяаршил, бүс нутгийн удирдлагыг бэхжүүлэх, зах зээлийн эдийн засагтай орнуудад монополийн эсрэг хууль тогтоомжийг либеральчлах зэргийг тооцон үздэгээрээ "Өрсөлдөөний дүрэм"-ийн онолоос ялгардаг.

Өрсөлдөөний орчны талаархи шинжлэх ухааны мэдлэгийг хөгжүүлэх өнөөгийн шатанд энэ үйл явцын талаархи шинжлэх ухааны мэдлэг хуримтлагдаж эхэлсэн үеэс онолын болон арга зүйн олон асуудал гарч байв. Үүнд:

- "өрсөлдөөний орчин", "бизнесийн орчин" гэсэн ойлголтуудыг хольж сольж ойлгох;
- өрсөлдөөний орчны эдийн засгийн өсөлт, эдийн засгийн хөгжлийн динамикт үзүүлэх нөлөөллийг тааруу судлах;
- өрсөлдөөний орчны хөгжлийг зохицуулах засаглалын байгууллагын үйл ажиллагаа болон түүний үр ашгийг үнэлэх механизм дутагдалтай байгаа зэрэг.

Энэхүү судалгаагаар бид "өрсөлдөөний орчин", "бизнесийн орчин" гэсэн ойлголтуудын нийтлэг болон ялгаатай шинжийг тодруулахыг зорилоо.

Шинжлэх ухааны бүтээлүүдэд өрсөлдөөний төлөв байдлыг тодорхойлоход "бизнесийн орчин"-оос илүү "өрсөлдөөний орчин" гэсэн ойлголтыг ашиглаж байна.

## II. ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Эдийн засгийн эдгээр үзэгдлийн мөн чанарыг авч үзвэл : Өөрсөлдөөний орчин гэх эдийн засгийн үзэгдлийг анх Германы эдийн засгийн бодлогын судлаач В.Ойкен тайлбарласан. Түүний тодорхойлсноор өрсөлдөөний орчин бол голлох болон зохицуулалтын дараах зарчимд суурилсан өрсөлдөөний дүрэм гэж үзнэ [1]. В.Ойкенээс гадна гадаадын томоохон эрдэмтэд өрсөлдөөний орчин бүрдүүлэх асуудалд анхаарал хандуулж байв.

Тухайлбал, Ж.Гэлбрейт өөрийн бүтээлүүддээ үр ашигтай өрсөлдөөний орчин бүрдэх нөхцөл нь төлөвшсөн корпорациуд, үнийн зохицуулалт, зах зээлийн хөгжил зэрэг юм гэжээ [2]. М.Портерын үзсэнээр салбар дахь боломж, аюул занал, мөн тохиолдож болох эрсдэл, боломжит өгөөж нь өрсөлдөөний орчныг тодорхойлдог [3]. М.Портер өрсөлдөгчид, худалдагчийн эрх мэдэл, хэрэглэгчид, нийлүүлэгчид, холбогдох салбаруудын байгууллагууд, засгийн газар (төр) зэрэг өрсөлдөөний орчны субъектууд байна гэжээ.

Д.Норт “гуравдагч ертөнц”-ийн орнууд ихэвчлэн “өрсөлдөөний орчныг бус монополийг бий болгодог” гэж эдийн засаг дахь өрсөлдөөний орчныг монополийн эсрэг сөргүүлэн тавьсан [4]. Энэ нь эдийн засгийн хөгжлийн хурд удаан байх нэг шалтгаан юм гэж Норт үзжээ.

И.Кирцнер өрсөлдөөний орчин бол бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулдаг өрсөлдөөний давуу талын талбар юм гэжээ [5]. М.Кастеллс "өрсөлдөөний орчин том хэмжээний харилцан холбогдсон сүлжээнд л оршин байх боломжтой" гэсэн байна [6].

Э.Мэйсон, Ж.Бейн нарын үзсэнээр өрсөлдөөний орчны хамгийн чухал бүрэлдэхүүн бол зах зээлийн бүтэц, энэ нь зах зээлийн субъектуудын зан төлөв, улмаар зах зээлийн үр ашигт нөлөө үзүүлж байдаг [7]. Өрсөлдөөний орчин бүрдүүлэх асуудлын судлаач Н.И. Усык "өрсөлдөөний орчин" нь ямар нэг улс, эсвэл бүс нутаг байгуулагдахтай холбоотой, өөрөөр хэлбэл хөгжил бүхий дэд бүтэцтэй, төсөв-татварын, мөнгө-зээлийн бодлогын нэгдсэн арга хэрэгсэлтэй, холбогдох институт бүрдсэн газар зүйн тодорхой нутаг дэвсгэрт суурилдаг гэжээ [8].

М.И.Крулкевич ба К.В.Синкова нар өрсөлдөөний орчныг бүс нутагтай холбон "аж ахуй эрхлэх субъектуудын өрсөлдөөний орчин бол тодорхой бүс нутгийн хэрэгцээг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах түвшин, аж ахуй эрхлэх

үйл ажиллагааны үр ашиг зэрэг үзүүлэлтээр өрсөлдөгчийн хөгжлийн ялгааг харуулдаг харьцангуй шинжтэй юм" гэж тодорхойлжээ [9].

А.С. Новоселов "орон зайн өрсөлдөөний онол талаас авч үзвэл, бүс нутгийн зах зээлийн газар зүйн хил хязгаар, төрөл бүрийн бүтээгдэхүүний борлуулалт, үйлдвэрлэл болон худалдааны бүс нутгийн онцлог шинж чанарыг харгалзан үзээгүй эдийн засгийн орон зайнаас ангид өрсөлдөөний орчин байх боломжгүй" гэж онцолжээ [10].

Тэрээр "Өрнөдийн эдийн засгийн ном зохиолуудад өрсөлдөөний орчныг судлах маркетингийн хандлага өргөн дэлгэрсэн. Үүнийг дэмжигчид өрсөлдөөний орчныг судлахдаа бөөний болон жижиглэнгийн худалдааны хөгжлийн бүс нутгийн онцлог, түгээлтийн сувгийн систем, таваарын урсгалын эрчим зэргийг тооцох шаардлагатай" гэснийг онцлог тэмдэглэсэн [10].

Өрсөлдөөний орчны зорилгыг тодруулах С.С.Собянины тодорхойлсон өрсөлдөөний орчин өөрөө зорилго биш, харин эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх хэрэгсэл гэсэн нотолгоо чухал юм [11]. Дараах тодорхойлолтууд нь өрсөлдөөний хөгжилд, тэрчлэн эдийн засгийн өсөлтөд бүхэлд нь нөлөөлөх өрсөлдөөний орчны талаарх ойлголттой нягт холбоотой дараах тодорхойлолтууд байна.

Д.Г.Чайковский өрсөлдөөний орчин бол хэрэглэгчид, түншүүд, ханган нийлүүлэгчдийн төлөө болон зах зээлд давуу тал олохын төлөөх үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан тэмцэл байдаг гэжээ [12]. А.Н.Куликова өрсөлдөөний орчин бол аж ахуй эрхлэгч субъектууд аж ахуйн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхгүйгээр зах зээлд эзлэх байр сууриа хадгалахад бэрхшээлтэй үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл гэж үзсэн [13].

Өрсөлдөөний орчны зарим тодорхойлолт бараа бүтээгдэхүүний зах зээлийн төвлөрлийн түвшин, өрсөлдөөний эрчим болон тэдгээрийн үйл ажиллагааны гол талууд зэрэг нөхцөлтэй нягт уялдаатай байдаг. Өрсөлдөөний орчныг тодорхойлоход тодорхой зах зээлийн үйл ажиллагааг зохицуулах онцлог багтдаг ч мөн нийтлэг шинжүүд байх ба бидний судалгаа түүнд чиглүүлнэ. И.В.Князев "дэлхийн практикт эдгээр (даатгал, санхүү, бараа, үйлчилгээ) зах зээлд нөлөөлөх зохицуулагчийн нөлөөлөл ижил байна" гэж тэмдэглэсэн [14].

Жишээ нь, В.А.Скворцова, И.Е.Медушевская нар жижиг бизнес эрхлэгч субъектүүдийн тоог өсгөж, өрсөлдөөнт зах зээлийн нягтралын хангалттай түвшинд хүргэх, түүнчлэн шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, трансакцийн зардлыг бууруулах замаар эрүүл өрсөлдөөний орчин бүрдүүлж, хөгжүүлэх боломжтой гэж үзжээ [15].

С.М.Янгирова “өрсөлдөөний орчныг нийгэм ба хувь хүн хоорондын холбоо харилцаа явагдах талбар” гэсэн философийн ойлголтыг дэвшүүлсэн. Уг холбоог хэрэгжүүлэхэд хувь хүн тухайн үйл ажиллагааны чиглэлтэй холбоотой тодорхой хэв маяг, зан төлөв, арга барилтай байхыг шаардлагатай. Энэ бол тухайн хүн, байгууллага, нийгмийн тогтолцооны хамгийн ерөнхий функциональ харилцааг илэрхийлдэг нийгмийн орчны ерөнхий чиг үүрэг юм [16].

К.Н.Костромитинов "өрсөлдөөний давуу байдлын төлөөх тэмцэл өрнөж байгаа газар өрсөлдөөний орчин бий болно" гэж өрсөлдөөний орчин ойлголтын талаарх сонирхолтой хандлага гаргажээ [17].

Н.Овчаренко: "улс орны сайн сайхан байдлын тогтвортой өсөлтийг хангах нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, өрсөлдөөний орчин дахь субъектүүдийн өрсөлдөх чадвар болон эдийн засгийн үр ашигт байдлыг бодит хөшүүрэг болгох түвшинд өрсөлдөөний орчин бүрдүүлэх шаардлагатай" гэж үзсэн [18]. Н.Овчаренко өрсөлдөөний орчин бүрдүүлэх дараахь зарчмуудыг тодорхойлсон. Үүнд:

1. Хэрэглэгчийн өрсөлдөөнт эрэлт хэрэгцээг өндөр түвшинд хангах.
2. Нөөцийн үр ашиггүй зардлыг (өрсөлдөөний үйл ажиллагаатай холбоогүй) хамгийн бага хэмжээнд байлгах.
3. Өрсөлдөгч аж ахуйн нэгжүүдийн удирдлагын бүтцийг хамгийн бага байлгах, удирдлагын зардлыг багасгах.
4. Төлбөрийн чадвартай өрсөлдөөнт эрэлтийн эдийн засгийн хувьд үр ашигтай сегментүүдийг бүрэн эзлэх.
5. Өрсөлдөөний эрэл хайгуулын болон инновацийн үйл ажиллагааг дээд зэрэгт хүргэх, өрсөлдөөний идэвхигүй аж ахуйн нэгжүүдийг шахах.
6. Хэрэглэгчдийн өрсөлдөөнт зан төлөвийг идэвхижүүлэх.
7. Аж ахуйн нэгж байгууллага, харилцагчдын шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн тохиолдолд тууштай, үр дүнтэй тэмцэх, энэ үйл ажиллагааг сурталчлах.
8. Бизнесийн байгууллагууд болон харилцагчидын өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, илрэлүүдтэй тууштай, үр дүнтэй тэмцэх, энэ үйл ажиллагааг сурталчлах [19].

Өрсөлдөөний орчин бүрдүүлэх үйл ажиллагааг судлахад А.А.Жук институцийн хандлагыг ашигласан. Тэрбээр эдийн засгийн албан ёсны институцийг бүрдүүлэх үед төр албан бус институцэд анхаарал хандуулж чадахгүй байгааг онцолжээ [20].

Тэрээр өрсөлдөөний орчны бүрэлдэхүүнийг тодорхойлсон. Үүнд: хувийн өмчийн институц (үүний дотор зохиогчийн эрх), бизнес эрхлэлтийн

институц, санхүү, эдийн засгийн гэрээний институц, монополийн эсрэг зохицуулалт хийх институц зэрэг юм [20].

Е.А.Остапенко өрсөлдөөний орчин бол аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг тодорхойлдог зах зээлийн хүч ба хүчин зүйлсийн нэгдэл юм гэжээ [21]. И.В. Князев “Бүтээгдэхүүний зах зээл дэх өрсөлдөөний орчны үнэлгээ нь удирдлагын болон засаглалын байгууллага, худалдагч ба худалдан авагч, өрсөлдөгч, түүнчлэн олон нийтийн болон шинжлэх ухаан, бизнесийн болон бизнесийн бус байгууллагууд, шинжээчдээс авсан бүх мэдээлэлд үндэслэнэ” гэж онцолжээ [22]. Өрсөлдөөний орчин ба өрсөлдөөний бодлогын уялдаа холбоог С.Н.Чирихин: “Өрсөлдөөний орчин нь төрөөс баримталж буй өрсөлдөөний бодлогын үр нөлөөнөөс хамаарна” гэжээ [23].

### III. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Өрсөлдөөний орчны мөн чанарыг тодорхойлсон олон хандлага байдаг. Тэдгээрийн зарим нь зах зээлийн бүтцэд, зарим нь тодорхой институцэд илүү их анхаарал хандуулсан ба гурав дах нь түүхий эдийн урсгалд, дөрөв дэх хэсэг нь нутаг дэвсгэрийн талаас тодорхойлсон байдаг. "Өрсөлдөөний орчин"-ыг тодорхойлсон хандлагуудын ерөнхий ангиллыг хүснэгт 1.3-т харуулав.

Хүснэгт 2. "Өрсөлдөөний орчин"-ыг тодорхойлсон хандлагууд

Өрсөлдөөний орчныг тодорхойлсон хандлага	Шинж чанар	Зохиогчид
Институцийн	Өрсөлдөөний орчин бол өрсөлдөөнт харилцааны мөн чанарыг тодорхойлдог институцийн орчин.	Веблен Т., Кларк Ж. М., Коммонс, Ж., Норт Д., Уильямсон О., Познер Р., Шаститко А.А., Жук А.А., Усик Н.И. болон бусад
Зохицуулалтын	Төрийн болон төрийн бус олон нийтийн холбоодын өрсөлдөөнд үзүүлэх нөлөөг тодорхойлдог өрсөлдөөний орчин бүрдүүлэх үйл явцад гол анхаарлаа хандуулдаг.	Кейнс Ж. М., Фридман М., Ойкен В., Самуэльсон П., Тироль Ж., Якунин В.И., Сулакшин С.С., Капогузов Е.А., Тотьев болон бусад.
Бүтэц - зах зээлийн (монополийн эсрэг)	Энэ нь зах зээлийн бүтцийг зохицуулахад төвлөрч, аж ахуйн нэгжийг өрсөлдөөний тухай хуулийг дагаж мөрдүүлэхэд чиглэдэг.	Мэйсон Э., Бэйн Ж., Шерер Ф., Князева И.В., Чирихин С.Н., Овчаренко Н.А., Лукашенко О.А., Скворцова Е.В., Медушевская И.Е. болон бусад.
Нийгэм-философийн	Нийгэм дэх өрсөлдөөний харилцаатай холбогдох харилцаануудыг шинжилнэ.	Вебер М., Мак Каллум Ж., Сантаяна Дж., Янгирова С.М. болон бусад.
Нутаг дэвсгэрийн (кластерын)	Өрсөлдөөний орчныг бүрдэн, хөгжиж буй нутаг дэвсгэртэй нь хамт авч үздэг. Нутаг дэвсгэрийн кластер,	Портер М., Канов В.И., Новоселов А.С., Гасанов М.А., Крулькевич М.И., Сынкова К.В. болон бусад.

Өрсөлдөөний орчныг тодорхойлсон хандлага	Шинж чанар	Зохиогчид
	өрсөлдөөний онцлогт голлон анхаарал хандуулдаг.	
Маркетингийн	Таваарын урсгал, үйлдвэрлэлийн том сүлжээ, нийлүүлэлт болон хэрэглээний бүтэц, зах зээл дэх эрэлт хэрэгцээ хангагдсан түвшин зэргийг онцолж авч үздэг.	Котлер Ф., Друкер П., Прахалад С., Хемел Г., Субботин А., Петиненко И.А., Костромитинов К.Н. болон бусад.

*Эх сурвалж: Судлаачдын нэгтгэсэнээр*

Эндээс үзвэл өрсөлдөөний орчныг тодорхойлох олон хандлага байдаг бөгөөд тэдгээрийн дийлэнх нь объектив шалтгааныг тодорхой авч үзэж чадаагүй юм.

Бид орчин үеийн эдийн засгийн онол дахь тодорхойлолтуудад үндэслэн өрсөлдөөний орчныг (нарийвчилбал) эдийн засгийн өрсөлдөөнт харилцааны хүрээнд ажиллах албан болон албан бус практик үйл ажиллагааны систем гэж тодорхойлж байна.

Өргөн утгаараа өрсөлдөөний орчин бол зах зээлийн эдийн засаг хөгжих нөхцөлийг бүрдүүлдэг эдийн засаг, нийгэм, дэд бүтэц болон бусад бүрдэл хэсгүүдийн нутаг дэвсгэрийн хувьд тусдаа систем юм.

Өрсөлдөөний орчин өөрөө төрийн эдийн засгийн бодлогын зорилго байх ёсгүй. Түүний гол зорилго бол эдийн засгийн системийг төрөлжүүлэн, улмаар бүс нутаг хоорондын болон олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гаргах боломж олгох үйл ажиллагааны таатай нөхцлийг аж ахуй эрхлэгчдэд бий болгох шийдвэрүүд гаргах явдал юм.

Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлс болон уялдаа холбооны системийг томъёолоход эдийн засгийн онолын яриа хэлэлцүүлэгт бизнесийн орчин гэх ойлголтыг ашигладаг бөгөөд бизнес эрхлэх таатай нөхцөлд онцгой ач холбогдол өгдөг. Гэхдээ энд өрсөлдөөний орчны мөн чанарыг тодорхойлоход ач холбогдолтой, тхүн амын боловсролын түвшин, өрсөлдөөнийг сурталчлах, өрсөлдөөний бодлогын хэрэгжилтийн чанар зэргийг авч үздэггүй. Үүний зэрэгцээ бизнесийн орчныг судалсны үр дүнд олж авсан мэдлэг мэдээлэл нь тухайн нутаг дэвсгэрийн хөрөнгө оруулалт татах боломжийг илүү нарийн үнэлэх, улмаар хөрөнгө оруулалтыг орчныг сайжруулах боломж олгодог олгодог учраас бизнесийн орчны судалгаа чухал байдаг. 3.3.Абдуллаева барууны орны бүтээлүүдэд "бизнесийн орчин" гэсэн ойлголт нэлээд ховор тохиолддог бөгөөд ихэвчлэн шинжлэх ухааны хэлэлцүүлэгт “бизнес эрхлэлтийн орчин”, "бизнесийн байгууллагын гадаад орчин" гэсэн тодорхойлолтыг ашигладаг гэж тодорхойлжээ [24].

А.Томпсон, Ж.Стрикланд, С.Славик болон бусад гадаадын судлаачид уг ойлголтын тодорхойлолтыг ашиглахгүйгээр бизнесийн орчны хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг.

С.Славик, С.Майтан нарын тайлбарласнаар бизнесийн орчны субъектууд нь өрсөлдөгчид, ханган нийлүүлэгчид, хэрэглэгчид, бусад туслах институцууд юм гэжээ [25]. А.Томпсон, Ж.Стрикланд нар бизнесийн орчны дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлохдоо нийгмийн болон иргэний зохицуулалтын нормууд, салбарын өрсөлдөөний түвшин, аж ахуйн нэгжийн гадаад, дотоод орчин, ёс зүйн зарчим болон бусад [26] гэж үзсэн.

О.А.Тойшева бизнесийн орчин бүрдүүлэх нь:

- Жижиг, дунд бизнесийг дэмжих;
- Хууль эрх зүйн хамгаалалт;
- Засгийн газрын бодлого;
- Санхүүжилтийн хүртээмж;
- Өрсөлдөөний орчны чанар [27].

Р.Б.Шестаковын ойлголтоор бизнесийн орчны эдийн засгийн тодорхойлогч нь бизнес эрхлэлтийг хөгжүүлэх эдийн засгийн харилцан хамаарал бүхий тогтолцоо юм [28].

О.Л.Рубцова эдийн засгийн төлөв байдал, санхүүжилтийн хүртээмж, хууль эрх зүйн орчин, засгийн газрын дэмжлэг зэрэг нь бизнесийн орчныг тодорхойлдог гэжээ [29]. Иймээс "Өрсөлдөөний орчин", "бизнесийн орчин" гэсэн ойлголтууд ижил төстэй, ялгаатай талуудтай юм.

*Хүснэгт 2. "Өрсөлдөөний орчин" ба "бизнесийн орчин" ойлголтуудын нийтлэг ба ялгаатай шинж чанарууд*

<b>Шинж чанар</b>	<b>Өрсөлдөөний орчин</b>	<b>Бизнесийн орчин</b>
Нутаг дэвсгэр	Бүх төрлийн нутаг дэвсгэрийн нэгж	Бүх төрлийн нутаг дэвсгэрийн нэгж
Объект	Салбарын зах зээл	Бизнес эрхлэгчид
Субъект	Бүх аж ахуй эрхлэгч байгууллагууд (төрийн, хувийн, ашгийн бус секторууд), төр, хэрэглэгчид, олон нийтийн байгууллага, нэгдсэн холбоод.	Бизнес эрхлэгчид (хувийн хэвшил), төрийн, олон нийтийн байгууллага, холбоод.
Гол институциуд	Монополийн эсрэг зохицуулалт	Хувийн өмч
Зохицуулах бодлогын гол чиглэлүүд	Өрсөлдөөний бодлого	Татварын бодлого, үйлдвэрлэлийн бодлого, мөнгө-зээлийн бодлого
Тодорхойлох үзүүлэлтүүд	Өрсөлдөөний эрчим, бүтээгдэхүүний зах зээлийн төвлөрлийн түвшин, тухайн салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн хурд зэрэг.	Аж ахуйн нэгжийн тоо, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний

Шинж чанар	Өрсөлдөөний орчин	Бизнесийн орчин
		хэмжээ, хөдөлмөрийн бүтээмж зэрэг.
Хөгжлийн гол арга хэрэгсэл	Хувьчлал, өрсөлдөөний сурталчилгаа, засаглалын бууруулах.	Татварын хөнгөлөлт, засаглалын саадыг бууруулах, бизнес эрхлэгчдийг дэмжих засгийн газрын хөтөлбөрүүд.

*Эх сурвалж: Судлаачдын нэгтгэсэнээр*

Өрсөлдөөний орчин ба бизнесийн орчин нь хоорондоо ижил төстэй, ялгаатай шинж чанартай, нягт холбоотой эдийн засгийн хоёр үзэгдэл юм. Эдгээр үзэгдлүүдийн нийтлэг шинжүүдэд нутаг дэвсгэрт хамаарах байдал, зарим субъектууд орно. Үүнээс гадна ялгаатай шинжүүдэд: хэрэв өрсөлдөөний орчин бүрдүүлэх үйл ажиллагааны логикийг өрсөлдөөний бодлого тодорхойлдог [30] бол бизнесийн орчны үйл ажиллагаанд татварын болон үйлдвэрлэлийн бодлого хамгийн их нөлөөлдөг. Эндээс үзвэл өрсөлдөөнийг хамгаалах байгууллага (монополийн зохицуулалт) нь өрсөлдөөний орчинд хамгийн их нөлөө үзүүлдэг, харин татварыг зохицуулах институцийг хэрэгжүүлснээр бизнесийн орчны төлөв байдалд таатай өөрчлөлт орно.

## ДҮГНЭЛТ

Өрсөлдөөний орчин ба бизнесийн орчин нь харилцан уялдаатай ойлголтууд боловч зохицуулалт хийх байгууллага, институц, хөгжүүлэх арга хэрэгсэл, төлөв байдлыг тодорхойлох систем зэргээрээ нэлээд ялгаатай юм.

Үүний зэрэгцээ судалгааны явцад өрсөлдөөний орчны гол шинж чанаруудыг тогтоосон. Үүнд:

1. *Нутаг дэвсгэрт хамаарах хамаарал:* өрсөлдөөний орчин нь ямагт аль нэг нутаг дэвсгэрт хамааралтай байдаг (нутаг дэвсгэрийн өрсөлдөөний орчин нь ихэвчлэн түүний байрладаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил хязгаартай давхацдаг).

2. *Өрсөлдөөнийг хамгаалах, хөгжүүлэх институтын зүгээс өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэхэд гүйцэтгэх үндсэн үүрэг:* бүтээгдэхүүний зах зээл дэх өрсөлдөөнийг хамгаалах (монополийг задлах, хувьчлал явуулах, шинэ аж ахуйн нэгжүүд бий болоход түлхэц үзүүлэх) нь өрсөлдөөний орчин бүрдэхэд хамгийн чухал нөхцөл юм.

3. *Төрийн зохицуулалт хийх боломж:* өрсөлдөөний орчин засгийн газрын бодлого болон институцийн нөлөөн дор байдаг. Бүтээгдэхүүний өрсөлдөөний орчинд засаглалын эрх бүхий байгууллага, институц шууд нөлөөлдөг бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар үйл ажиллагаанд нь зарим өөрчлөлт хийх боломж

гардаг. Үүний зэрэгцээ албан бус институцийн өрсөлдөөний орчинд үзүүлэх нөлөөг харгалзан үзэх нь чухал юм.

4. *Эдийн засгийн өсөлт, хөгжилд үзүүлэх нөлөө* – аливаа бүтээгдэхүүний зах зээлд өрсөлдөөний орчин бүрдүүлэх зорилгыг эдийн засгийн өсөлт, хөгжилтийн асуудал гэж үзэж болно (өрсөлдөөний таатай орчин нь ДНБ өсөх, төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэх, хүн амын сайн сайхан байдал дээшлэхэд нөлөөлдөг).

5. *Нутаг дэвсгэрт байгаа хүн амын боловсрол, сэтгэлгээг зах зээлийн өрсөлдөөний орчны хүчин зүйл болгон үзэх шаардлага*: боловсрол нь зах зээлийн өрсөлдөөний орчны зайлшгүй бүрдэл хэсэг юм. Учир нь боловсрол өрсөлдөөний хүрээнд менежерүүд, бизнес эрхлэгчид, ажилчдыг үр дүнтэй хамтран ажиллахад бэлтгэж өгдөг. Өрсөлдөөний соёл хөгжихөд хүмүүс шударга өрсөлдөх зан төлөвтэй болж улмаар эдийн засгийн үр өгөөж нэмэгддэг.

Дүрэм, дэг журамд үндэслэсэн В.Ойкены "өрсөлдөөний дүрэм" -тэй харьцуулж үзвэл өрсөлдөөний орчин нь бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээл, түүнчлэн эдийн засаг дахь өрсөлдөөний шинж чанарыг тодорхойлдог институц, дэд бүтэц, санхүү, соёлын нөхцлүүдийг багтаасан газар нутгийн тусгаар систем болохыг энэ судалгаагаар тогтоолоо.

Өрсөлдөөний орчин, бизнесийн орчин гэдэг эдийн засгийн үйл хөдлөлийн хооронд ялгаа байгаа нь тэдгээрийн төлөв байдлыг зохистой оношлох үнэлгээний систем хэрэгтэй болохыг харуулж байна. Энэ үнэлгээг төрийн өрсөлдөөний бодлогыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах ёстой.

#### ***Ном зүй***

- [1] З. Абдуллаева, "Благоприятная предпринимательская среда и условия её формирования в регионе," Региональные проблемы преобразования экономики. №4, pp. 266-275, 2011.
- [2] Stefan Slavik, *Strategické riadenie podniku*, Bratislava: Sprint v.fra. , 1999.
- [3] A. Thompson and A. Strickland, *Strategic Management: Concepts and Cases*, McGraw-Hill Inc., US, 1999.
- [4] О. Тойшева, "Механизм управления предпринимательской средой," Вестник университета (Государственный университет управления). № 9, pp. 60-64, 2012.
- [5] Р. Шестаков, "Как улучшить предпринимательскую среду малого бизнеса?," Российское предпринимательство. №5, p. 18, 2010.
- [6] О. Рубцова, "Предпринимательская среда и малый бизнес в России," Маркетинг МВА. Маркетинговое управление предпринимателей. Т.6. №1, p. 103, 2013.
- [7] В. Якунин, С. Сулакишин, Н. Фонарева and К. и. д. Тотьев, "Государственная конкурентная политика и стимулирование конкуренции в Российской Федерации," Монография в 2-х томах. Т. 2. Москва, 2009.
- [8] В. Ойкен, *Основные принципы экономической политики*, Москва: Издательская группа «Прогресс», 1995.

- [9] J. Galbraith, *The New Industrial State*, Princeton University Press; Revised Edition, 2007.
- [10] M. Porter, *The competitive advantages of nations*, Free Press; Illustrated edition, 1998.
- [11] D. North, *Institutions, Institutional Change and Economic Performance*, Cambridge University Press, 1990.
- [12] I. Kirzner, *Competition and Entrepreneurship*, University of Chicago Press; New edition, 1978.
- [13] M. Catells, *The Information Age: Economy, Society and Culture*, Wiley-Blackwell, 1999.
- [14] E. Mason, *Economic concentration and monopoly problem*, *Journal of Farm Economics* Vol. 40, No. 2, 1958.
- [15] Н. Усик, "Формирование конкурентной среды и конкурентная политика," *Теоретическая экономика*, №4, pp. 33-42, 2012.
- [16] М. Крулькевич and К. Сынова, "Использование мониторинга конкурентной среды как инструмента регуляторной политики региона," *Экономика промышленности*. №1, pp. 33-37, 2009.
- [17] А. Новоселов, "Теоретические аспекты исследования региональных рынков," *Регион: экономика и социология*, №3, pp. 3-22, 2008.
- [18] С. Собянин, "Конкурентная среда - основа экономики региона," *Налоги. Инвестиций. Капитал*, pp. №1-3, 2005.
- [19] Д. Чайковский, "Корпоративная модель управления регионом как условие формирования конкурентной среды на региональном и межрегиональном уровне.," *Вестник Оренбургского государственного университета*. № 8, 2009.
- [20] А. Куликова, "Методология оценки состояния и пути развития конкурентной среды на федеральном и региональном уровне," *Корпоративное управление и инновационное развитие экономики Севера: Вестник Научно-исследовательского центра корпоративного права, управления и венчурного инвестирования Сыктывкарского государственного университета*. №4, p. 10, 2012.
- [21] *Материалы круглого стола, "«Конкуренция и монополия»*, "Идеи и идеалы". № 1, 2012.
- [22] В. Скворцова and И. Медушевская, "Государственное регулирование конкуренции в современной экономике России," *Известия Пензенского государственного педагогического университета им. В.Г. Белинского*. №24. , pp. 449-456, 2011.
- [23] С. Янгирова, "Конкурентная среда: основные характеристики," *Исторические, философские, политические и юридические науки. Культурология и искусствоведение. Вопросы теории и практики*. №6-3, p. 208, 2011.
- [24] К. Костромитинов, *Оценка состояния конкурентной среды: учеб. пособие*, Иркутск, 2004.
- [25] Н. Овчаренко, "Методологические подходы к созданию и развитию конкурентной среды в промышленности России," *Известия Санкт-Петербургского университета экономики и финансов*. №4. , pp. 20-26, 2011.
- [26] Н. Овчаренко, "Современные подходы к управлению конкурентной средой в промышленности," *Фундаментальные и прикладные исследования кооперативного сектора экономики*. №6, pp. 9-15, 2010.
- [27] А. Жук, "Место и роль государства в регулировании конкурентной среды," *Вестник Дніпропетрвського університету. Серія «Економіка»*. Вип. 5 (2), pp. 10-19, 2011.
- [28] Е. Остапенко, "Использование кластерного анализа для сегментации конкурентной среды санаторно-курортных организаций рекреационного региона," *Региональная экономика*. №15, p. 30, 2012.
- [29] И. Князева, *Антимонопольная политика в России: учеб. пособие для студентов вузов, обучающихся по специальности «Нац. экономика»*, Москва: Омега-Л, 2011.

[30] С. Чирихин, "Диагностика состояния конкурентной среды: проблемы и решения," Журнал экономической теории. № 3, pp. 233-242, 2013.